



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/196-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: <a href="mailto:arifin.audit@gmail.com">arifin.audit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС стандарт	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ДЗМОУБ	Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллага



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.БОЛД ТАНАА**

2025.02.25 № 10А-2025/196/НА-ОТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус сургууль нь БШУЯ, БЕГ, аймгийн Боловсролын газар, Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагаас 30,955.7 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, хөгжим хэрэгсэл, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж

432502285

байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>221,653,663.55</b>	<b>257,893,004.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	90,247,076.30	142,661,085.34
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	90,247,076.30	142,661,085.34
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	90,247,076.30	142,661,085.34
31211	Төрийн сангийн харилцах	90,247,076.30	142,661,085.34
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	351,153.90	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	351,153.90	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	131,055,433.35	115,231,919.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	126,835,433.35	113,167,919.35
35410	Бичиг хэргийн материал	269,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	34,087,300.22	21,238,521.82
35430	Сэлбэг хэрэгсэл	1,481,053.60	1,481,053.60
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,885,000.00
35460	Хүнсний материал	3,428,621.60	2,210,659.00
35470	Бусад хангамжийн материал	87,569,457.93	86,352,684.93
35600	Мал амьтад	4,220,000.00	2,064,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,203,102,809.98</b>	<b>1,151,254,378.10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,203,102,809.98	1,151,254,378.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,043,566,309.98	991,717,878.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	867,904,238.64	867,904,238.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-133,173,530.88	-160,267,060.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,873,344.55	231,918,589.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,851,246.18	-166,481,490.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,758,618.56	102,029,018.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,291,151.61	-60,592,928.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	181,529,024.26	181,529,024.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,176,519.04	-32,395,168.32
39217	Ном	26,993,531.68	28,073,654.68
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	159,536,500.00	159,536,500.00
39301	Програм хангамж	1,371,100.00	1,371,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,371,100.00	-1,371,100.00
39303	Бусад биет бус хөрөнгө	159,536,500.00	159,536,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,424,756,473.53</b>	<b>1,409,147,382.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>545,959.90</b>	<b>00.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	545,959.90	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	283,600.90	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	262,359.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,424,210,513.63</b>	<b>1,409,147,382.79</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,424,210,513.63	1,409,147,382.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,177,033.64	818,177,033.64
51101	Өмч: - төрийн	818,177,033.64	818,177,033.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	35,172,420.78	20,109,289.94
51210	Өмнөх үеийн үр дүн	35,172,420.78	35,172,421.68

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,063,131.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	570,861,059.21	570,861,059.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,424,756,473.53</b>	<b>1,409,147,382.79</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>906,650,675.13</b>	<b>1,186,600,119.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,649,012.09</b>	<b>39,674,832.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,649,012.09	39,674,832.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,037,548.00	1,249,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,035,900.00	1,124,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,001,648.00	125,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	19,540,408.50	30,955,768.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	7,071,055.59	7,469,764.24
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>877,001,663.04</b>	<b>1,146,925,286.98</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	801,128,000.00	1,052,912,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	801,128,000.00	1,052,912,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	75,873,663.04	94,012,386.98
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,873,663.04	94,012,386.98
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>870,911,769.03</b>	<b>1,201,507,250.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870,911,769.03</b>	<b>1,201,507,250.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	849,178,541.63	1,181,095,429.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	578,957,498.42	831,432,446.62
210101	Үндсэн цалин	465,760,358.99	567,111,322.01
210102	Нэмэгдэл	90,247,939.63	221,807,746.39
210104	Урамшуулал	22,949,199.80	42,513,378.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,059,816.15	99,554,864.53
210201	Тэтгэврийн даатгал	62,875,032.11	70,249,011.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,500,399.94	7,723,091.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,693,159.97	2,875,630.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,040,371.88	3,564,145.72
210205	Эрүүл мэндийн даатгал	9,950,852.25	15,142,984.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,877,363.94	73,139,886.98
210301	Гэрэл, цахилгаан	13,459,896.09	6,916,966.98
210302	Түлш, халаалт	48,901,547.85	59,912,880.00
210303	Цэвэр, бохир ус	4,515,920.00	6,310,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	2,000,000.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,223,600.00	18,987,500.00
210604	Урсгал засвар	9,223,600.00	18,987,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,154,400.00	10,513,365.97

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,035,900.00	1,529,561.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,118,500.00	8,983,804.24
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>104,905,863.12</b>	<b>145,467,365.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,222,482.25	38,100,915.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	808,250.00	5,122,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,875,130.87	102,244,199.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,733,227.40</b>	<b>20,411,821.60</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,733,227.40</b>	<b>20,411,821.60</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,600,728.40	14,855,921.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,132,499.00	5,555,900.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>35,738,906.10</b>	<b>-14,907,131.74</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>156,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	156,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>00.00</b>	<b>-156,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>35,738,906.10</b>	<b>-15,063,131.74</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>880,039,211.04</b>	<b>1,148,174,586.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,037,548.00</b>	<b>1,249,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,037,548.00</b>	<b>1,249,300.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,037,548.00	1,249,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,035,900.00	1,124,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,001,648.00	125,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>877,001,663.04</b>	<b>1,146,925,286.98</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>801,128,000.00</b>	<b>1,052,912,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	801,128,000.00	1,052,912,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>75,873,663.04</b>	<b>94,012,386.98</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,873,663.04	94,012,386.98
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>807,508,601.72</b>	<b>1,076,320,577.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>807,508,601.72</b>	<b>1,076,320,577.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>783,099,517.72</b>	<b>1,056,843,118.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>591,053,834.50</b>	<b>831,081,292.72</b>
210101	Үндсэн цалин	438,603,505.14	523,308,995.30
210102	Нэмэгдэл	129,215,459.36	265,258,919.20
210104	Урамшуулал	23,234,870.00	42,513,378.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,894,640.18</b>	<b>99,554,864.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,645,642.91	66,639,309.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,976,546.21	8,230,999.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,693,159.97	4,121,283.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,045,742.87	4,109,515.13
210205	Эрүүл мэндийн даатгал	10,533,548.22	16,453,756.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,877,363.04</b>	<b>75,024,886.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,459,896.09	6,916,966.98
210302	Түлш, халаалт	48,901,546.95	61,797,880.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	4,515,920.00	6,310,040.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,996,300.00</b>	<b>18,987,500.00</b>
210604	Урсгал засвар	8,996,300.00	18,987,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,180,800.00</b>	<b>10,513,365.97</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,035,900.00	1,529,561.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,144,900.00	8,983,804.24
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,096,580.00</b>	<b>21,681,208.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,412,680.00	16,558,958.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,683,900.00	5,122,250.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,409,084.00</b>	<b>19,477,459.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,409,084.00</b>	<b>19,477,459.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,276,585.00	13,921,559.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,132,499.00	5,555,900.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>72,530,609.32</b>	<b>71,854,009.04</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>19,440,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>19,440,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>19,440,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	19,440,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>-19,440,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>72,530,609.32</b>	<b>52,414,009.04</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>17,716,466.98</b>	<b>90,247,076.30</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>90,247,076.30</b>	<b>142,661,085.34</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,177,033.64	570,861,059.21	-105,551,118.99	1,283,486,973.86
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>818,177,033.64</b>	<b>570,861,059.21</b>	<b>-105,551,118.99</b>	<b>1,283,486,973.86</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	104,984,633.67	104,984,633.67
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,177,033.64	570,861,059.21	35,172,420.78	1,424,210,513.63
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>818,177,033.64</b>	<b>570,861,059.21</b>	<b>35,172,421.68</b>	<b>1,424,210,514.53</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,063,131.74	-15,063,131.74

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,177,033.64	570,861,059.21	20,109,289.94	1,409,147,382.79
-----	---------------------------------------	----------------	----------------	---------------	------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	90,247,076.30		-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,238,946,000.00	1,095,760,577.94	143,185,422.06	88.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,238,946,000.00	1,095,760,577.94	143,185,422.06	88.4
210	Бараа, үйлчилгээний зардал	1,214,706,300.00	1,076,283,118.94	138,423,181.06	88.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	944,562,000.00	831,081,292.72	113,480,707.28	88.0
210101	Үндсэн цалин	616,492,100.00	523,308,995.30	93,183,104.70	84.9
210102	Нэмэгдэл	309,561,400.00	265,258,919.20	44,302,480.80	85.7
210104	Урамшуулал	18,508,500.00	42,513,378.22	-24,004,878.22	229.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,070,300.00	99,554,864.53	18,515,435.47	84.3
210201	Тэтгэврийн даатгал	80,287,800.00	66,639,309.16	13,648,490.84	83.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,445,700.00	8,230,999.40	1,214,700.60	87.1
210203	ҮОМШӨ ний даатгал	4,722,800.00	4,121,283.86	601,516.14	87.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,722,800.00	4,109,515.13	613,284.87	87.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,891,200.00	16,453,756.98	2,437,443.02	87.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,360,000.00	75,024,886.98	1,335,113.02	98.3
210301	Гэрэл цахилгаан	18,900,000.00	6,916,966.98	11,983,033.02	36.6
210302	Түлш, халаалт	50,500,000.00	61,797,880.00	-11,297,880.00	122.4
210303	Цэвэр, бохир ус	6,960,000.00	6,310,040.00	649,960.00	90.7
2106	Эд хогшил худалдан авах	19,000,000.00	18,987,500.00	12,500.00	99.9
210604	Урсгал засвар	19,000,000.00	18,987,500.00	12,500.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,217,200.00	10,513,365.97	703,834.03	93.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,529,561.73	-1,529,561.73	-
210806	Мэдээллийн технологийн зардал	11,217,200.00	8,983,804.24	2,233,395.76	80.1
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	45,496,800.00	41,121,208.74	4,375,591.26	90.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,368,200.00	35,998,958.74	4,369,241.26	89.2

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,128,600.00	5,122,250.00	6,350.00	99.9
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,239,700.00	19,477,459.00	4,762,241.00	80.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,239,700.00	19,477,459.00	4,762,241.00	80.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	18,683,800.00	13,921,559.00	4,762,241.00	74.5
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,555,900.00	5,555,900.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,238,946,000.00	1,148,174,586.98	90,771,413.02	92.67
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,237,614,500.00	1,148,174,586.98	89,439,913.02	92.77
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,142,254,500.00	1,052,912,900.00	89,341,600.00	92.18
	Орон нутгийн төсвөөс	95,360,000.00	94,012,386.98	1,347,613.02	98.59
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,331,500.00	1,249,300.00	82,200.00	93.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,206,500.00	1,124,300.00	82,200.00	93.19
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,000.00	90,000.00	35,000.00	72.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	90,247,076.30		-90,247,076.30	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		142,661,085.34	-142,661,085.34	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	37	37	-	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь “Хамтаараа хөгжсөн, зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,609.2 мянган төгрөгөөр буюу 1,09 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	90,247.1	142,661.0	52,413.90
Авлага	351.2	0.00	- 351.2
Бараа материал	131,055.4	115,231.9	-15,823.50
Үндсэн хөрөнгө	1,203,102.8	1,151,254.3	-51,848.50
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,424,756.5</b>	<b>1,409,147.3</b>	<b>-15,609.20</b>
Өр төлбөр	546.0	0.00	-546.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,424,210.5	1,409,147.3	-1,063.20
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,424,756.5</b>	<b>1,409,147.3</b>	<b>-15,609.20</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 142,661.0 мянган төгрөг болж 52,413.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хэмнэлттэй холбоотой,
- Бараа материал дансны үлдэгдэл 115,231.9 мянган төгрөг болж, 15,823.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 105,561.4 мянган

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан төгрөгийн бараа материал худалдан авсан, БЕГ, аймгийн Боловсролын газар, ДЗМОУБ-аас нийт 7,469.7 мянган төгрөгийн сурах бичиг, газрын зураг зэрэг сургалтын хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, 128,854.7 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалсан,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,151,254.3 мянган төгрөг болж, 51,848.50 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,440.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, тавилга, эд хогшил зэргийг худалдан авсан, БШУЯ, БЕГ, аймгийн Боловсролын газар, ДЗМОУБ-аас 30,955.7 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, хөгжим хэрэгсэл, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 102,244.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 699,834.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 129,483.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 829,318.2 мянган төгрөгөөр баталсан боловч тайлант онд 9 удаа төсөвт зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,142,254.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 95,360.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,206.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 125.0 мянган төгрөг зэрэг нийт 1,238,946.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 1,052,947.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 94,012.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,124.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 90.0 мянган төгрөг зэрэг нийт 1,148,174.6 мянган төгрөг төвлөрүүлж, 1,095,760.5 мянган төгрөгийг зарцуулж, 143,185.4 мянган төгрөгийг хэмнэж, үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,095,760.5 мянган төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь хүүхэд хамгаалал хөтөлбөрийн зардлыг 1,069.0 мянган төгрөг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 129,810.2 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 4,762.2 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардлыг 4,749.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-байр ашиглалт	1,286.50	1,273.80	12.70	99.0
2	80233-хүүхэд хамгаалал	1,369.00	300.00	1,069.00	21.9
3	80312-сургалт семинар	957.50	957.50	-	100.0
4	81605-эрүүл мэндийг дэмжих	1,282.20	1,282.00	0.20	100.0
5	81801-үдийн цай	18,683.80	13,921.56	4,762.24	74.5
6	81816- зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	20,590.50	20,020.00	570.50	97.2
7	81834-стандарт сургалт	1,067,768.70	937,958.48	129,810.22	87.8
8	81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа	28,737.50	23,988.30	4,749.20	83.5
9	81844-сургалтын орчин сайжруулах	35.00	-	35.00	0.0
10	81848 - Сурах бичгийн түрээс	1,206.50	1,206.50	-	100.0
11	81875-сургалтын нэмэлт хөтөлбөр	1,668.80	840.06	828.74	50.3
12	81823-нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	-	-	-	0.0
	Дүн	1,143,586.00	1,001,748.20	141,837.80	87.6
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	95,360.00	94,012.30	1,347.70	98.6
	<b>Нийт дүн</b>	<b>1,238,946.00</b>	<b>1,095,760.50</b>	<b>143,185.40</b>	<b>88.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Баялаг баян тулга” ХХК, “Өгөөж ундром дэлгэрэх” ХХК, “Ундрах түм ” ХХК, “Цахим ертөнц” ХХК, “Алтан есүй” ХХК, “Галил этос” ХХК, Зэлтэрийн зам” ХХК -иуд болон иргэн С.Долгорсүрэн, Д.Мөнхцэцэг нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулах болон хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлэх зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 870,911.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,063.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 167 мэдээлэл байршуулахаас 160 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт 1, 7 дугаар сар,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал -1,7 дугаар сар,
- Дараа жилийн төсвийн төсөл,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файлууд оруулаагүй
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1 дүгээр сар,
- Худалдан авах ажиллагааны тайлан
- 2023 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй

Энэ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт болон 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өр төлбөр үүсгэсэн, сурах бичгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, төлбөр тооцоо хийхдээ е-баримтаар баталгаажуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	3,821.1	3	3,821.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>3,821.1</b>	<b>3</b>	<b>3,821.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,842.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөв.

#### 5.1 Албан шаардлага:

1. Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголгүйгээр зөвхөн амжилт гаргасан тухайн сард буюу 6 сард тус бүр 20-25 хувиар тооцон 4 хүнд 1,222.1 мянган төгрөгийн, 12 дугаар сард 10 хүнд 3,620.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, 09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж, батлагдсан төсөвт багтаан нэмэгдлийг сар бүр олгож байх албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал:

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**1.1 Илрүүлэлт:** Зайлшгүй шаардлагын улмаас номын санчаар орон тоонд батлагдаагүй хүний нөөц, бичиг хэргийн ажилтны ажил үүргийг хавсруулан гүйцэтгэсэн гэх үндэслэлээр албан тушаалын цалингийн 30 хувиар тооцон хавсран ажилласны нэмэгдэл цалин олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

## 2.Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой:

**2.1 Илрүүлэлт:** 2023 оны эцэст 4,220.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 140 мал тоологдсоноос тайлант онд зудын улмаас 25 толгой нь хорогдсон болон сургуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зэргээр зарлагдаж, жилийн эцэст 2,064.0 мянган төгрөгийн 79 толгой мал тоологдсон байна. 1 үхрийг 600.0 мянган төгрөгөөр, ямааг 10.0 мянган төгрөгөөр, хонийг 20.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн нь зах зээлийн үнэлгээтэй нийцэхгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Малын тоо толгойг зах зээлийн үнээр үнэлж бүртгэн, хөдлөл өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу үнэлж, дүгнээгүй нэмэгдлийг сар бүр олгоогүй	1	4,842.0			1	4,842.0							

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Малыг зах зээлийн үнээр үнэлж, бүртгээгүй	1					1				
Орон тоонд батлагдаагүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлсэн	1					1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,842.0</b>			<b>1</b>	<b>4,842.0</b>	<b>2</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээлэл байршуулаагүй	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 145/А.1850385  
ОМ-2025/196/МА-СТА-ТМЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголгүйгээр зөвхөн амжилт гаргасан тухайн сард буюу 6 сард тус бүр 20-25 хувиар тооцон 4 хүнд 1,222.1 мянган төгрөгийн, 12 дугаар сард 10 хүнд 3,620.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, 09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 6-д "Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно", 7-д "Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар сургуулийн захирал Б.Болд, нягтлан бодогч А.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



